



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/271

Булган сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Сожид” ХХК /РД:2105632/-ийн эзэмшиж буй Булган сум 6 дугаар баг Л.Энэбиш 1 дүгээр гудамж 113 тоотод байршилтай 6308003388 нэгж талбар бүхий эрүүл мэндийн байгууллага зориулалттай 580 м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр сунгасугай.

2. “Сожид” ХХК-ийн захирал Л.Бүдсүрэнтэй газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг “Сожид” ХХК (Л.Бүдсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

